

ОХУ-ЫН СИБИРЬ, АЛС ДОРНОДЫН БҮС НУТГАА ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

*М.Татьяна**

ХІХ зууны сүүлд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Дж.Хей: “Газрын дундад тэнгис өнгөрсөн үеийн далай, Атлантын далай одоо үеийн далай, Номхон далай бол ирээдүй үеийн далай”¹ гэж хэлсэнчлэн эдүгээ Ази Номхон далайн бүс /АНДБ/ бол дэлхийн эдийн засгийн хүчтэй төв болжээ. Энэ бүсэд дэлхийн хүн амын тал нь 3.5 млрд. хүн, мөн Япон, Хятад, Австрали, Шинэ Зеланд, Тайвань, Өмнөд Солонгос, Гонконг, Сингапур зэрэг үйлдвэрлэлийн хөгжингүй орнууд оршдог. Эдгээр орнуудын эдийн засаг маш хурдан хөгжсөн бөгөөд банк санхүү, техник технологи, үйлдвэрлэлийн нөөц, боловсон хүчин, маркетинг, үйлчилгээний салбар, харилцаа холбооны өргөн боломжтой, газар нутаг, байгалийн ба ажиллах хүчний нөөц ихтэй. Тус бүс нутгийн эдийн засгийн ач холбогдол ихээхэн нэмэгдэж, дэлхийн эдийн засгийн тэнцвэр нь Хойд Атлантын орнудаас Зүүн Ази руу чиглэсэн байна. Иймээс ОХУ АНДБ-ийн, түүний дотор Зүүн Хойт Азийн орнуудтай найрсаг, хамтын ажиллагааны харилцаа тогтоохыг урьтал болгож, хуучин баримталж байсан Европ ба Америкийг чиглэсэн Оросын гадаад бодлогод өөрчлөлт орсон билээ. АНДБ-ийн орнуудтай, нэн түрүүнд Хятад, Япон, БНСУ, БНАСАУ, Монгол, АПЕК-ийн орнуудтай, мөн АНУ, АСЕАН-ы орнуудтай, тогтмол ажил хэргийн холбоотой байхгүй бол Орос зөвхөн өөрийн хүчээр Сибирь болон Алс Дорнодын өргөн уудам дэвсгэр дээр орчин үеийн түвшинд эдийн засаг, соёлыг ганцаараа бие даан түгээж чадахгүй.²

1980-д оны дундаас ЗХУ АНДБ-д стратегийн изоляцид орж тусгаарлагдсан байв. Харин тэр үед Америкийн санаачилсан бүс нутгийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулсаар байжээ. Учир нь тэдгээр нь ганц цэргийн биш, мөн эдийн засгийн хамтын ажиллагаа явуулав. АСЕАН үйл ажиллагаагаа аль хэдийнэ 1967 онд эхлэн явуулж, Индонези, Малайзи, Сингапур, Тайланд, Филиппин зэрэг орнуудыг нэгтгэсэн байв. 1990-д оны үед тус бүс нутагт шинэ байгууллагууд бий болж, хуучин байгууллагууд ч хүчээ авч эхэлсэн бөгөөд АПЕК байгуулагдсанаар АНДБ-ийн орнууд нэгдсэн зах зээлтэй болсон юм. Мөн Баруун Европод болж буй интеграцийн явдал нь АНДБ-д түлхэц өгөв. Харин энэ үед Орос АНДБ-д явагдаж буй интеграцийн процессоос холдсон байв.

*М.Татьяна - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Үүнд: - Оросын гадаад бодлого боловсруулахад тухайн цаг үедээ Гадаад Хэргийн Яам, Гадаад Худалдааны Яам, Цэрэг аж үйлдвэрлэлийн цогцолбор гэсэн 3 гол байгууллага байнга өрсөлддөг байсан юм. 1990-ээд оны сүүлээр нөлөө бүхий үндэстэн дамнасан корпорациуд /ҮДК/ буюу санхүү-үйлдвэрлэлийн бүлэглэлүүдийн нөлөө ихсэж, өөрийн ашиг сонирхлоо Кремльд дээд зэргээр лоббиддөг болжээ. Энэ үеэс улс төрийн хүрээнд тэдгээрийн засгийн эрхийн төлөө тэмцэл хурцдаж, санхүү, үйлдвэр, худалдааны олигархын эрх мэдэл хүчтэй болов. Мөн 1990-ээд оны эхэн хагаст Гадаад бодлогын номлолын тухай маш их маргаан явагджээ. АНДБ-ийн хувьд “шинэ реализм” ба “туйлын зөвлөлцөл” /“сверхкомпромисс”/ хэмээх 2 үзэл баримтлал өрсөлдөж “шинэ реализм” нь давж гарч ирсэн юм. Маш хүчтэй Атлантын лобби нь Өрнөдийн болон АНУ-д чиглэсэн бодлого явуулж, мөн Ойрхи Дорнодод анхаарлаа төвлөрүүлсэн байна.

- Хүйтэн дайны үед Сибирь, Алс Дорнод нь цэрэг-улс төрийн ач холбогдолтой байж, Хятад болон Япон-АНУ-ын эвслийг тогтоон барих зориулалттай байсан. Иймээс Сибирийн дивизууд хамгийн сайн дайчин чадвартай дивизуудын тоонд орж байсан бөгөөд ОХУ-ын Номхон далайн усан цэргийн флот бол ЗХУ-ын Зэвсэгт хүчний нэгэн том хэсэг нь байв.

- Өөр нэг шалтгаан нь: Сибирь, Алс Дорнодод Москватай ярилцах хэмжээний гадаад харилцааны байгууллага байгаагүй. Мөн тэр үе Оросын эдийн засгийн хямралын үетэй таарч, Сибирь, Алс Дорнодод өөрийн бүс нутгийн сонирхлоо Москва, АНДБ-д лоббидох нөлөө бүхий ҮДК байгаагүй.

- Хамгийн гол объектив шалтгааныг дурьдвал, Орос гадаад бодлогодоо эдийн засгийн асуудлыг бус, улс төрийн талыг илүүд баримталж байсан. Тус бүс нутгийн эдийн засгийн сайн бүтэц байгуулж чадаагүй. Улс орон эдийн засгийн гүнзгий хямралд орж, бүс нутгийг хөгжүүлэх хөрөнгө оруулалт, технологийн потенциал байхгүй байсан юм. /Тус бүсийн эдийн засгийг колонийн шинж чанартай эдийн засаг гэж зарим оросын эрдэмтэд нэрлэдэг байна.^{3/} Сибирь, Алс Дорнод хоёр Оросын түүхэнд, ялангуяа социализмын үед ЭЗХТЗ-ийн хүрээнд түүхий эдийн хавсаргын үүрэг роль гүйцэтгэж, голдуу ашиг олохын зорилгоор хандаж байсан. Стратегийн ач холбогдолтой томоохон зарим үйлдвэрүүд тус байгууллагын хүрээний шийдвэрээр баригдсан. /жишээ нь: Усть-Илимский целлюлозный завод/ Мөн Братский хөнгөн цагааны үйлдвэр стратегийн өндөр ач холбогдолоо алдаагүй бөгөөд социализмын үед БНАГУ, Унгар, Чехословак, Польш төдийгүй, Англи,

Австри, Голланд, Итали зэрэг орнууд түүний бүтээгдэхүүнийг болон нефть, байгалийн хий г.м. их хэмжээгээр импортлодог байв. Иймээс Сибирь, Алс Дорнод ганц социалист бус Барууны орнуудыг түүхий эдээр тогтмол хангадаг байжээ.

- 1990-ээд оны эхээр ОХУ-ын дотоод байдал ихээхэн хямарсан жилүүд байсан бөгөөд ДНБ 1990 оныхтой харьцуулбал бараг 2 дахин буурч, газар тариалан зогсонги байдалд орж, гадаад өр өссөн байв. Мөн Чеченьд 1994-1996 онд дэгдсэн дайн, 1999 онд сэдэрсэн түүний үргэлжлэл улсын дотоод байдлыг хүндрэлтэй болгосон юм. Оросын улс төрийн байдал нэн тогтворгүй байсныг Засгийн газар нь энэ үед 5 удаа солигдсон жишээ тодорхой харуулсан билээ.

Сибирь, Алс Дорнод нь байгалийн нөөцөөр Оросын хамгийн баян газарт тооцогддог хэдий ч, улсын хэмжээнд хамгийн ядуу хүмүүс амьдардаг билээ.

1980-аад оны үед тус бүс нутгийн геополитикийн статус эрс өөрчлөгдсөн. Үүнд:

- Хятадтай харилцаа сайжирсан;
- Японтой харилцаа хэвийн болох шатанд хүрсэн;
- АНУ-тай Номхон далайн бүсэд сэргөлдөхөөс Орос татгалзсан.

Түүнчлэн ОХУ-ын гадаад худалдаа бодлогын төвлөрүүлэлтийн хямрал нь Алс Дорнодод бие даан АНДБ-д гарахад түлхэц болсон. Сибирь, Алс Дорнодын байгалийн нөөц Зүүн Ази, Японы сонирхлыг татах боломжтой. Алс Дорнод нь 4 сая шоо дөрвөлжин газартай, 7 сая гаруй хүн амтай. Мөн тус хоёр бүсийн байгалийн нөөц 29 трлн.доллараар үнэлэгддэг билээ.⁴

Тухайн үед Сибирь болон Алс Дорнодын Бүгд Найрамдах Улс байгуулах тухай бүс нутгийн нийгмийн хүрээнд их яригдаж байжээ. Энэ нь эртнээс улбаатай юм. Бүр 1917 онд Г.Н.Потанин /1835-1920/ Сибирийн БНУ-ын даргаар сонгогдоод, хоёрдахь Америк болж чадах уу үгүй юу гэсэн яриа их түгээмэл байв. Үүнийг областничество буюу сибирский сепатаризм гэж нэрлэж байсан. Г.Н.Потанин оросын түүхч, археологич Н.М.Ядринцевт /1842-1894/ “Шинэ Америкийн Колумб Танаа...” хэмээн хандаж бичдэг байжээ. Гэвч Ф.М.Достоевский, А.Бакунин нар тухайн үед Сибирийн сэхээтнүүдийн дунд дэлгэрч байсан “хоёрдахь Америк” болох гэсэн үзэл санааг эсэргүүцэн “Бүх гол мөрөн нь Хойд мөсөн далайд цутгадаг учраас Сибирьт ирээдүй байхгүй”⁵ гэсэн байр суурь баримталж байв. Энэ бол сибирьчуудын зүгээс тус бүсийн ашиг сонирхлыг үл тоон орхигдуулдаг байсантай холбоотой бөгөөд,

салан тусгаарлах гэдэг утга агуулаагүй болно. Америкийн жишээтэй харьцуулбал тус бүсэд нийгэм-эдийн засгийн бааз суурь дутагдаж байв.

Тухайн үед АНДБ-д АНУ болон бусад хөгжингүй орнууд эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэхийг чухалчилж байсан боловч, Москва анхааралдаа авсангүй. Орос тус орнуудтай зөвхөн ашигт малтмал болон цэрэг аж үйлдвэрлэлийн цогцолборт голчилж ажиллав. ОХУ-ын Цэрэг аж үйлдвэрлэлийн цогцолбор нь Зүүн-Өмнөд Азийн зэвсгийн зах зээл дээр байр сууриа олж авсан бөгөөд одоогоор Малайзи, Вьетнам, Хятад зэрэг орнууд Оросоос нисэх онгоц өргөнөөр худалдаж авч байна. 1996 оноос АСЕАН-д Оросын статус дээшилж, АНУ, Хятад, Япон, Канад, Өмнөд Солонгос, Энэтхэг, Австрали, Шинэ Зеланди зэрэг орнуудтай эрх тэгш оролцдог болсон нь Оросыг найдвартай түнш гэж үзэж байгаагийн илрэл юм.⁶ 1997 онд АНДБ-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага АПЕК, мөн 1998 онд АНДБ-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулгын ПЕКК-т бүрэн эрхт гишүүн болсон юм. ОХУ-ын 2000 онд шинээр батлагдсан Гадаад бодлогын үзэл баримтлалд АНДБ нутагтай харилцах харилцаагаа өргөн тусгасан юм.⁷

Социализмын үед Орост гадаад бодлогын номлолыг улс төрийн ба цэрэг, зэвсгийн байгууллагууд голдуу хэрэгжүүлж, эдийн засгийн байгууллагуудын хүрээ бага байсан. Сүүлийн үед хувийн компаниуд гадаадын компаниудтай хамтран аж ахуйн нэгжүүдийг байгуулдаг болсон. Энэ нь тус бүсэд ажил хэргийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц болж байгаа юм.

ҮДК тус бүсийн хөгжилд хөндий ханддаг. Энэ нь

- Сибирь, Алс Дорнодын байгалийн нөөцийг монополичлон эзэмших, өөрийн бүтээгдэхүүнээ Европ руу гаргах;

- Хувийн сектор ба улсын байгууллагуудын хоорондын хуулийн зөрчил;

- Дотоодын ба гадаадын хөрөнгө оруулалтыг төрөөс дэмжих, хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй;

- Улсын гадаад худалдааны эдийн засгийн байгууллагууд үйлдвэрлэлийн баазаас тасарсан, ихэнх үйлдвэрүүд хувьчлагдсан;

- Улсын санхүү ба үйлдвэрлэлийн тогтворгүй байдал, улсаас дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь, мөн ҮДК тийм ч хүчирхэг биш байгаатай холбоотой.

Түүнээс гадна, Сибирь, Алс Дорнодод хятадын хууль бус цагаачид олноор орж ирсэн нь зөвхөн эдийн засгийн биш, улс төрийн хүчин зүйл болсон. 1 сая гаруй /зарим мэдээллээр 2 сая орчим/ хууль бусаар

орж ирсэн хятадууд амьдарч байгаа нь Оросын олон нийтийн санааг зовоож байгаа бөгөөд мөн оросын зарим судлаачид “чимээгүй түрэмгийлэл”⁸ эхэлсэн гэж үзэж байна. Учир нь Москва тус газарт цэргийн тоогоо хоёр дахин бууруулсан нь яваандаа байдал хүндэрч магадгүй гэсэн болгоомжлол төрүүлж байгаа юм. Гэтэл үүний зэрэгцээ Сибирь болон Алс Дорнодын өргөн уудам газрыг хөгжүүлэх, мөн аж ахуйн газар, үйлдвэрүүдийн төсвийн ашиггүй зардлыг багасгах хэрэгтэй учир хятад иммигрантуудын нөөцийг ашиглах тухай яриа гардаг билээ. Мөн Хойт хязгаарын районуудад хүн ам суурьшуулах хэрэгтэй байна.

Сибирь болон Алс Дорнодын бүс нутаг нь ЗХУ задарч, Зөвлөлтийн улс төр, эдийн засгийн тогтолцоо богино хугацаанд хурдан задарсан бөгөөд Оросын шинэ удирдлага улс орныхоо цаашдын арга зам ба гадаад, дотоод үндсэн чиглэлийн талаар тодорхой төсөөлөлгүй байсан амаргүй үеийг өөрийн хүчээр даван туулсан юм. Ардчилсан засаглал, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр ОХУ гадаад бодлогынхоо чиглэлийг шинээр тодорхойлжээ. Энэ үед улс үнний либералчлал болон зах зээлийн механизмд орсноор эдийн засгийн динамик эергээр өөрчлөгдөж, улмаар Барууны зүгээс улс төрийн дэмжлэг, урт хугацааны зээл, тусламж авах өргөн боломжийг нээх болно гэсэн ойлголт давамгайлах болсон. Гэвч энэ бүхэн нь эцэстээ хэт туйлширсан үзэл, үндэс муутай найдлага байсныг цаг хугацаа харуулсан билээ.

Зүүн Хойт Азийн бүс нутгийн интеграцийн хүрээнд ОХУ-ын субъектуудын үүрэг роль ихсэж, аль хэдийнээ 1991 онд нийгэмлэгүүдийг бий болгож, 1999 онд “ОХУ-ын субъектуудын эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгүүдийн зохион байгуулалт ба үйл ажиллагааны ерөнхий зарчмын тухай” гэсэн Холбооны хууль 1999 оны 12-р сард 17-ны өдөр батлагдсан. Түүний зорилго нь нийгэмлэгт хамрагдсан нутгийн интеграцчилал ба нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхийн тулд, мөн байгуулагч гишүүдээ нэгтгэх, нэгдсэн эдийн засгийн болон хуулийн орон зайг байгуулан ажиллуулахын зэрэгцээ Оросын эдийн засгийн стратегийг дотоод зах зээл рүү чиглүүлэх, бүс нутаг хооронд том комплексуудыг хөгжүүлэх, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадны хөрөнгө оруулалт татахад оршино.

Монголын хил орчмын болон бүс нутгийн Орос дахь гол түншүүд гэвэл Алтай, Буриад, Тыва-гийн БНУ-уд, Эрхүү, Чита мужууд зэрэг айл зэргэлдээ нутгуудийг нэрлэж болно. Нилээд алслагдсан нутгаас Халимаг-Тангч, Татарстан, Саха-Якутын БНУ-уд, Новосибирск, Кемерово, Свердловскийн мужууд орж байна.

“Сибирийн хэлэлцээр” нь 1991 оны 2-дугаар сарын 8-ний өдөр байгуулагдаж, дотроо 19 субъектуудыг багтаасан билээ. Гэвч тус бүс нутгийн үйл ажиллагаа одоо хүртэл эрчимжээгүй, гарсан нэг ч шийдвэр биелээгүй, зөвхөн цаасан дээр үлдсэн байна. Цаашид энэ байгууллага ирээдүйгүй гэсэн ч яриа байдаг. Харин Байгалийн эдийн засгийн чуулга уулзалт энэ хугацаанд 2 дахин зохион байгуулагдаж, анхдугаар чуулга уулзалт нь 2000 оны 9-дүгээр сард, 2-р чуулга уулзалт нь 2002 оны 9-дүгээр сард болж өнгөрсөн билээ. Хэдийгээр тус хоёр уулзалтын эцэст ОХУ-ны Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн тогтоол болон “ХХI зууны Ази Номхон далайн бүс нутаг дахь Оросын хөгжлийн стратеги”, “Сибирийн эдийн засгийн хөгжлийн стратеги” нэртэй баримт бичиг тус тус батлагдаж, үе шатчилсан үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн шинж агуулсан баримт бичиг баталсан ч гэсэн тодорхой үр дүн гараагүй байна.

Одоо Сибирь, Алс Дорнодын байгалийн хийн маш өргөн хэмжээний төсөл боловсруулагдаж байна. Үүний дагуу Сибирийн хий Шар тэнгист гарч, 2-дахь төсөл нь Хойд Солонгосоор дамжин Өмнөд Солонгосын аль нэг боомт хүртэл хүрэх юм. Гэвч технологийн салбарт Оросыг АНДБ-ийн орнуудтай харьцуулахад, Оросын аж үйлдвэрлэлийн хөгжил доогуур бөгөөд түүний хүчирхэг потенциал нь технологийн шинэтгэл хийхийг шаардаж байна. Ихэнх аж үйлдвэрийн аж ахуйн нэгжүүд, тэр тусмаа цэргийн салбарт, өөрийн төв байгууллагуудаас хэдэн мянган км-аар алслагдсан тул хэцүү байдалд орсон. Маш их цэрэгжсэн бүс нутагт хөрөнгө оруулалт багассанаар аж үйлдвэрлэл зогсож, ажилгүйдэл ихэсч, хуучин эдийн засгийн харилцаа тасарч, бүс нутгийн хөдөлмөрийн хуваарь алдагджээ. Мөн Москвайг тогтмол харилцаа тасарсан, тээврийн зардал маш ихээр нэмэгдсэн зэрэг нь Сибирь, Алс Дорнодод бараа үйлдвэрлэхэд эдийн засгийн хувьд ашиггүй болгодог. Орост цахилгаан харилцаа холбоо, үйлчилгээний салбар, аялал жуулчлалыг нэн түрүүнд хөгжүүлэх хэрэгтэй байна.

Хүн амын менталитет болон түүхэн цаг үед өөр өөр хөгжлийн үе шатанд байсан төдийгүй, шашин, үндэстэн, угсаатны психологийн талаас ялгаатай байсан. Учир нь сибирьчууд бол хэзээд баруун бүс нутгийн оросуудаас эрс ялгаатай, Сибирь болон Алс Дорнодын нийгмийн байдал ч Оросын түүхэнд өөр байр суурь эзэлж байсан. Хэдийгээр тус газарт үргэлж өөр газрын нүүдэлчид /хаант оросын ч, зөвлөлтийн үед ч/ амьдарч байсан боловч, Оросын хэмжээнд хоорондоо нягтарсан, оросын маш баялаг уран зохиол, соёлын үнэт зүйл дээр хүмүүжсэн

интернациональч нийгэм байгуулагдаж, үүнийг “суперэтнос”⁹ г.м. мэтээр нэрлэдэг билээ. Энэ бүс ЗХУ-ын задралын амаргүй үеийг тайван даван туулж, одоо ч гэсэн Оросын бусад газраас харьцангуй тайван, үндэсний болон шашны зөрчилдөөнгүй, эвтэй найрсаг үндэстнүүд оршдог юм. Тус газар нь хэзээд өөрийн онцлогтой, төвөөс өөр нөхцөлтэй, цаг уур, газар зүйн хувьд ялгаатай, харин нийгмийн асуудал хүнд хэвээрээ байна. Тус газрын ихэнх нь бусад газрын нүүдэлчид байсан болохоор ЗХУ задарсны дараа төвлөрүүлэлтийн систем, хөдөлмөрийн хуваарь алдагдаж маш олон залуучууд ажилгүй, ирээдүйд итгэл муутай, гэмт хэрэг, архи, хар тамхи, ДОХ өвчин /Эрхүү хот нь ДОХ-ын тархалт болон хар тамхинд донтогсдын тоогоор ОХУ-д 1-р байр эзэлдэг билээ/¹⁰ гэх зэрэг нийгмийн ноцтой асуудлуудтай тулгарсан юм. Тус бүс нултийн хүмүүсийн менталитетын сайн тал алдагдаж эхлэн, маш их хөдөлмөрч зан, байнга байгалийн үзэгдэл, гай гамшигтай тэмцэж, зөвхөн өөрийн хар хүч, хөдөлмөрөөр амьдрах, аж ахуйн нөхцөл, нийгмийн тогтвортой байдал алдагдаж байгаа нь хүмүүсийн сэтгэлийг зовоож байна. Энэ нь нийгмийн ноцтой зөрчилтэй холбоотой юм.

Гэвч тус бүс нутаг эртнээс асар их оюуны нөөцтэй билээ. Оросын шинжлэх ухаан, техник, улсын хөгжилд тус газрын нэртэй эрдэмтэд, төрийн зүтгэлтнүүдийн хувь нэмэр их юм. Энэ уламжлалт хандлага одоо ч гэсэн хүчтэй хэвээрээ байна. Энд ОХУ-ын ШУА-ийн Сибирийн болон Алс Дорнодын салбарууд, түүний дотор олон тооны эрдэм шинжилгээний байгууллагууд, Эдийн засгийн хөгжлийн ба хамтын ажиллагааны Номхон далайн төв, зөвхөн Сибирьт 100 гаруй их, дээд сургуулиуд бий. Мөн Новосибирск хотын Академгородокт ороход М.Ломоносовын “Оросын ирээдүйг Сибирь нэмэн баяжуулна...” гэсэн үг нүдэнд тусдаг билээ.

Гэвч хуучин асуудлуудыг шийдэж эхэлсэн боловч, бүс нутагт шинэ асуудлууд гарч ирсэн. ОХУ ДОХ өвчний тархалтын хурдцаар дэлхийд 1-р байр эзлэж байна. Сүрьеэ өвчин их байгаа бөгөөд энэ өвчний тархалтын хурдац улсын хэмжээнд иргэний дайны үеийнхтэй адил хэмжээнд хүрчээ. Мөн ОХУ-д хар тамхинд донтогсдын тоо 7 дахин нэмэгдэж, хагас сая гаруй тэнэмэл хүүхдүүд байна.¹¹

Хоёр жилийн өмнөх Дэлхийн Банкны илтгэл дээр үндэслэн НҮБ-ийн хийсэн судалгааны дүн саяхан гарчээ. Уг судалгааны дүнгээр ДОХ өвчний тархалтаас шалтгаалан 2020 онд ОХУ-ын эдийн засагт их хүндрэл учрах бөгөөд хэрэв өвчний тархалт энгийн хурдтай үргэлжилбэл, тус өвчин Оросын ДНБ-ний 5%-ийг эзэлж, яаралтай арга

хэмжээ авахгүй бол үйлдвэрлэлийн хэмжээ нь 2020 онд 14%-иар буурах юм байна. Москва дахь Дэлхийн Банкны салбарын ерөнхий эдийн засагч Кристоф Рюлийн мэдээлснээр: “Орост 2 жилийн өмнө хийсэн судалгаанаас хойш байдал арай сайжирсан. Гэхдээ ДОХ өвчин ирээдүйд тус улсад гадаадын хөрөнгө оруулалт татахад саад болно. Одоогоор Орост тус өвчний тархалт тийм өндөр бус бөгөөд, харин түүний тархалтын хурдчаар ОХУ дэлхийд тэргүүлэх байр эзэлж байна. Энэ нь ирээдүйд гадаадын хөрөнгө оруулагчдад сөрөг нөлөө үзүүлнэ. ДОХ өвчний хяналт, сэргийлэх арга хэмжээ хангалтгүйгээс эдийн засгийн өсөлт төдийгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалтын байдалд муугаар нөлөөлнө. Багаар бодоход, дээрх үзүүлэлт нь 2010 онд 5,5 %, 2020 онд 14,5%-иар буурах хандлагатай” юм байна. Мөн НҮБ-ийн шинжээчдийн бодлоор, Орост үйлдвэрлэлийн олборлох салбар хамгийн их хүндрэлтэй тулгарах бөгөөд энэ нь халдвар тээгчид түүхий эд байрладаг бүс нутагт голдуу төвлөрдөг гэдэг дээр тэдгээрийн судалгаа үндэслэж байгаа юм. Иймээс олборлох салбар тус өвчинд хамгийн их өртөгдөх юм байна. НҮБ-ийн судалгаагаар, ОХУ-ын байгалийн хийн экспорт 2045 онд 11-27%, олборлолт тус өвчний тархалтаас шалтгаалан 5-13%-иар буурна. Өнгөт металлын үйлдвэрлэл 1/4, экспорт 1/3, нефтийн олборлолт 6-16%, экспорт нь 8-19%-ийр тус тус буурч болзошгүй. Кристоф Рюлийн хэлснээр: “Дэлхийн олон орнуудад ДОХ өвчний тархалт Оросоос их байгаа, гэвч ОХУ-д байдал 3 хүчин зүйлээр хүндэрч байна. 1-рт: оросын хүн амын өсөлт ер нь буурах хандлагатай байгаа бөгөөд энэ нь Африкийн орнуудтай харьцуулвал, тэнд ДОХ-оос хамааралгүй хүн ам өсөх хандлагатай байгаа билээ. 2-рт: өвчтөн тусламж үзүүлэх нөөцөөр Орос хөгжилтэй орнуудаас хомс. 3-рт: тус вирусын эсрэг хямд эм хэрэглэх систем Орост байхгүй, харин Бразил мэтийн орнууд дэлхийн томоохон эм үйлдвэрлэдэг компаниудаас хямд эм нийлүүлэх тухай тохиролцоонд хүрсэн” байна. ДБ мэдээлснээр, ДОХ өвчин Оросын эдийн засгийн хөгжилд удахгүй бэрхшээл учруулна, “...иймээс оросын удирдлагууд тайвширч болохгүй” хэмээн К.Рюль тэмдэглэсэн байна. Харин Эдийн засгийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний удирдагч Евгений Ясин “иймэрхүү илтгэл урьдчилсан байдлаар бодит мэдээ өгөхөөс гадна, тус асуудалд нийгмийн анхаарлыг татах зорилготой. ДОХ өвчний асуудал бол Оросын хувьд маш чухал юм. Харин болж буй байдал дээр үндэслэн эдийн засгийн урьдчилсан тооцоо хийхэд хэцүү. Иймэрхүү яриа залуучуудын анхаарлыг тус өвчинд хандуулах боломжтой” гэж

тэрээр хэлжээ.¹² Гэвч энэ асуудал оросын нийгмийн санааг зовоосоор байна.

Сибирь, Алс Дорнод АНДБ-ийн интеграцчилалд орох сонирхолтой байгаа. Энэ бол дэлхийн хамгийн том хэрэглээний зах зээл юм. Олон улсын худалдаа тус бүсийн эдийн засгийн хөгжлийн механизм болсон. Иймээс олон улсын худалдааны хуулийн чухал асуудлууд АНДБ-ийн тэргүүн орнуудын анхаарлын төвд байгаа билээ.

Дүгнэлт

Оросын “шилжилтийн эмзэг үеийг” Сибирь болон Алс Дорнодын бүс нутаг маш тэвчээртэй хүлээн, тууштай бус, алдаатай явагдаж байсан бодлогын золиос болон цаг хугацааг өнгөрөөв. 1990 оноос хойшхи хугацаанд ОХУ нь ганц түүхий эд болон зэвсэг худалдаалж ашиг олсон хэвээр байв. Энэ бүхний ард Сибирь, Алс Дорнодын нөөц баялаг, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн тодорхой хэмжээ эзэлж байсан нь мэдээж. Гэтэл одоо бол тус бүс нутгийн дотоод бодит байдал болон олон улсын байдал цаг алдалгүй бодитой арга хэмжээ авахыг шаардаж байна.

- Тус бүс нутгийг хөгжүүлэх зорилгоор баталсан хуучин бүх баримт бичиг, гэрээ хэлэлцээрүүдийг шинээр авч үзэхдээ, маш том /19 субъектыг хамарсан “Сибирийн хэлэлцээр” шиг/ төсөл биш, харин бодит байдалд нийцсэн авсаархан богино хугацааны төслүүдийг хэрэгжүүлэх талаас анхааралдаа авч, нийгмийн асуудлыг хэрхэвч орхиж болохгүй. Төвөөс санхүүжилттэй тусгай нийгмийн хөтөлбөр бүс нутгуудад боловсруулах; үүнд тус газрын менталитет болон үндэстэн, угсаатны хөгжлийн онцлогуудыг харгалзах,

- Эдийн засгийн хувьд төвөөс хэт хамааралтай хэвээрээ бөгөөд эдийн засгийн хөгжил нь харилцан адил бус, өөрчлөлтийн зохион байгуулалт болон эдийн засгийн нөхцлүүдийг бий болгох ажил зогсонги байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлэхдээ заавал нийгмийн асуудалтай хосолсон шийдвэр боловсруулах. Нэгэн сайн талыг дурьдвал, Сибирь, Алс Дорнодын хүн ам нь бүхий л шинэтгэл, өөрчлөлтийг хүлээж авах бүрэн чадвар, нөөцтэй гэж хэлж болно, зөвхөн төрийн зөв зохицуулалт шаардагдаж байна. Аль ч улсын хөгжлийг тодорхойлохдоо, тэр улсын хүн амын амьжиргааны түвшингийн үзүүлэлтээр тодорхойлдог уламжлалт арга байдаг гэдгийг бодолцох,

- Тус газрын хүн амын суурьшилтын байдал өөрчлөгдөж, хөдөөнөөс хот руу шилжилт ихэссэн учраас шинэ жижиг хот, тосгон суурилуулах, өөр газраас, ялангуяа АНДБ-ийн орнуудаас хөрөнгө

оруулалтын шугамаар шинэ оршин суугчдыг татахдаа шинэ технологи оруулах урьдчилсан нөхцөл тавихын зэрэгцээ нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрт тэдгээрийн хувь нэмрийг нэмэгдүүлэх талаас авч үзэх;

- Дэд бүтэц, зам тээвэр, мэдээлэл, цахилгаан харилцаа холбоо, үйлчилгээний салбар, аялал жуулчлал /экотуризм/-ын салбарт өөрийн иргэддээ хувийн секторт ажиллах бодитой нөхцөл бүрдүүлэх, төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх, ер нь хувийн болон улсын секторын хоорондох харилцааг шинэчлэх. Үүний тулд татвар багасгах, ажил хэрэгч үйл ажиллагааг урамшуулах, өрсөлдөөнт орчин бүрдүүлэх, дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах, мөн өндөр технологийн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, төрийн захиалгын системийг боловсронгуй болгох бодитой арга хэмжээ авах;

- Шинжлэх ухаан, технологийн харилцааг гүнзгийрүүлэх, нэн түрүүнд, хөрш орнуудын болон АНДБ-ийн орнуудын туршлагыг судлахдаа тэдгээр орнуудын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран тогтмол харилцаа тогтоох, хамтарсан төсөл боловсруулах.

ОХУ-ын өмнө эл асуудлууд шийдлээ хүлээж байна. Аливаа улс орны гадаад, дотоод улс төрийн бодлого нь эцсийн дүнд эдийн засгийн ашиг сонирхлоос урган гардаг учир мөн ОХУ дэлхийн болон бүс нутгийн интеграцчилалын явцад оролцох сонирхолтой байгаа юм. Иймээс цаг алдалгүй арга хэмжээ авах, тус бүсэд баримталж буй бодлогод өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгохыг цаг үе шаардаж байна. Гадаадын улс орнууд тус бүс нутгийг сонирхсоор байна. Байгалийн эдийн засгийн чуулга уулзалтын анхдугаар хуралд гадаадын 4 улс: уламжлалт хөршүүд болох БНХАУ, Япон, Монголоос гадна Европын Холбооны эдийн засгийн гол тулгуур болох ХБНГУ,¹³ мөн 2-дахь чуулга уулзалтанд нийт 35 улсын төлөөлөгчид оролцсон нь тус бүс ирээдүйд эдийн засгийн эрчимтэй орон зай болох, гадаадынхны сонирхлыг татаж байгаагийн илрэл мөн болно. Мөн Сибирь нь Монгол Улстай газар зүйн байршлын хувьд зэрэгцээ оршдог бөгөөд Орос-Монголын харилцаанд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Орос-Монголын бүс хоорондын хамтын ажиллагааны хэтийн төлөв бүхий чиглэлүүдэд геологи ба уул уурхай, аж үйлдвэрийн зэрэг салбарт хамтран ажиллахаар хэлэлцсэн учир хөрш орныхоо олон улсын практикт хуримтлуулсан зах зээл, түүний геополитик, геозэдийн засгийн өвөрмөц байдлын онцлог, Монголын тавцан дээр эртнээс их гүрнүүдийн Ази дахь ашиг сонирхлын мөргөлдөөн болж байсан учир эл байдлыг

өөртөө ашигтайгаар эргүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах г.м. боломж сүвэгчлэхэд дөхөм болно.

Сибирь, Алс Дорнодын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлого бол ОХУ-ын хувьд бүс нутгийн чанартай бус, нийт үндэсний асуудал бөгөөд улс орны АНДБ-д гарах, дэлхийн зах зээл, олон улсын болон бүс нутгийн интеграцид нэгдэн орох ганц гарц, тулгуур юм. Мөн Оросын бүрэн бүтэн байдлыг хадгалж бэхжүүлэхэд, Оросын Европ, Ази хоёрыг холбох Евразийн түүхэн онцгой үүргээ биелүүлэхэд тэргүүн зэргийн ач холбогдолтой билээ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. З.Бжезинский "Великая шахматная доска", М., 1999.
2. Солодовник С."Найдём ли место в АТР?", МЖ., 1992.
3. А.Д.Агеев "Сибирский и американский сепаратизм", "Россия и Восток: взгляд из Сибири в конце столетия", Иркутск, 2000.
4. Абазов Р. "Политика России в АТР: смена парадигм", "Международная экономика и международные отношения". №2, 1997
5. А.Д.Агеев "Сибирский и американский сепаратизм", "Россия и Восток: взгляд из Сибири в конце столетия", Иркутск, 2000.
6. Оросын алдарт дипломатч Н.Н.Соловьевын намтараас.
7. ОХУ-ын Гадаад бодлогын Үзэл Баримтлал. 2002 он.
8. Дмитрий Жуков: Желтый дракон не дремлет. В планах евразийцев Китаю отводится весьма солидное место в придуманном ими "мошном антиатлантическом блоке". 16.5.2003
<http://www.sv-rus.ru/article.php?nid=89>
9. Е.И.Лиштованный "К вопросу о сибирско-монгольской "обшности", "Россия и Восток: взгляд из Сибири в конце столетия", Иркутск, 2000.
10. <http://irkutsk-online.irk.ru/>, <http://rusich.by.ru/news/rasa08.htm>
11. <http://euro.svoboda.org/ll/russia/1003/ll.103103-3...> /Апест акций компании "ЮКОС" и судьба финансируемых концерном социальных программ/
12. <http://www.vedomosti.ru/stories/2004/02/18-68-03.h...> Минус 14% ВВП: по расчётам ООН столько будет стоить России эпидемия СПИДа. С.Иванова, И.Федюкин, А.Николаева "Ведомости", 18 февраля 2004 г.
13. ХБНГУ-ын Эдийн засаг, технологийн яамны орлогч сайд биеээрээ хүрэлцэн ирж оролцсон. Европын орнууд Оросоос өргөнөөр нефть, байгалийн хий импортлодог бөгөөд Германы байгалийн хий, нефтийн импортлодог ОХУ 1-р байр эзэлдэг. 2000-2001 онд Орос дангаараа ОПЕК-ийн нийт гишүүн-орнуудаас их хэмжээний нефть тус улсад экспортлосон бөгөөд 1972-2001 оны хооронд 30 жилийн дотор 600 млрд.куб.м. байгалийн хий нийлүүлсэн байна. Герман ОХУ-ын эдийн засагт ГШХО-ийн хэмжээгээр 3-р байр эзэлдэг. ХБНГУ нийт импортынхоо байгалийн хийн 46%, нефтийн 29%, өнгөт металлын 11%-ээс дээш, химийн эрдэс тэжээл 13%-ийг Оросоос авдаг байна. Мөн сүүлийн үед нүүрс их хэмжээгээр авдаг болжээ.
http://www.inves.ru/info/online/overview/2002/E_ob...,
<http://www.germany.polpred.ru/2002/60.htm>